



ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОЛОНТ БОЛГО

BANK REFORMER

Хөрөнгө оруулалтын цогц зөвлөх үйлчилгээ

БАНКУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ

- » Системийн нөлөө бүхий банкны тухай
- » Системийн нөлөө бүхий 5 банкны салбарт эзлэх хувь
- » Санхүүгийн харьцуулалт
- » Зохистой харьцааны үзүүлэлтүүд



2021 ОНЫ 3-Р УЛИРАЛ



СИСТЕМИЙН 5 БАНК 2021 ОНЫ 3-Р УЛИРАЛ

Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн дагуу “банкны системд нөлөө бүхий банк” гэж сүүлийн 6 сарын турш банкны системийн нийт активын 5 хувиас дээш хувийг эзэлж байгаа банкныг хэлнэ.

МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Мөн Монгол банкнаас баталсан “Банкны системд нөлөө бүхий банкныг тогтоох аргачлал”-ийн дагуу банкны хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүнд эзлэх хувь, банкны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал зэрэг шалгуурыг нэгэн зэрэг баримтлан банкны тогтолцоонд нөлөөтэй гэж Монголбанкнаас тогтоосон банкныг “*системийн нөлөө бүхий банк*” гэх юм.

Мөн системийн нөлөө бүхий банкныг тогтоохдоо тухайн банк татан буугдахад дотоодын эдийн засаг, банк санхүүгийн салбарт үүсэж болзошгүй нөлөөллийг харгалзан үздэг. Аливаа банк татан буугдахад банкны харилцагч, бусад банк санхүүгийн байгууллагад учрах шууд болон шууд бус хохирол, эрсдэл, тухайн банкныг богино хугацаанд татан буулгах бололцоо, банкны салбарын тухайн үеийн нөхцөл байдал, ач холбогдлыг харгалзан үздэг байна.

2021 оны байдлаар Монгол улсын банкны системийн нөлөө бүхий банкууд нь Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк болон Хас банкууд байгаа бөгөөд 2021 оны 3 дугаар улирлын байдлаар эдгээр 5 банк нийлээд банкны салбарын нийт активын 93.6%, цэвэр зээлийн 93.2%, өөрийн хөрөнгийн 89.8%-ийг бүрдүүлж байна.

Банкуудын салбарт эзлэх хувь (2021Q3 байдлаар):

	Нийт актив	Өөрийн хөрөнгө	Цэвэр зээл	Нийт хүүгийн орлого	Цэвэр ашиг
	33.0%	31.6%	32.8%	35.8%	42.2%
	23.4%	26.7%	23.2%	18.8%	14.3%
	19.1%	14.4%	17.5%	17.6%	3.3%
	9.4%	9.4%	11.6%	11.4%	7.3%
	8.6%	7.7%	8.2%	9.5%	7.5%

Эх сурвалж: Банкуудын 3 дугаар улирлын санхүүгийн тайлан

Эх сурвалж: Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль 4.1.3 заалт

Эх сурвалж: Монгол банкны ерөнхийлөгчийн тушаал А-104

Банкуудын санхүүгийн үзүүлэлт:

2021 оны 3 дугаар улирлын байдлаар нөлөө бүхий банкуудын нийт хөрөнгө бүгд өсөлттэй гарлаа. Тэр дундаа Хаан банкны хөрөнгө үндсэн хөрөнгө болон зээлийн багцын өсөлтөөр дамжин 19% өсөв. Харин Худалдаа хөгжлийн банк нь мөнгөн хөрөнгө болон санхүүгийн бусад хөрөнгүүд нэмэгдсэнээр актив 17% өсчээ. Хас банк хөрөнгө оруулалтаа бууруулсан ч зээлийн багцаа нэмэгдүүлснээр нийт хөрөнгө өмнөх оны мөн үеийн түвшинд хадглагдаж байна.


Хас банкны хувьд өөрийн хөрөнгийн өсөлтийн дийлэнх хэсгийг цэвэр ашгийн өсөлт бүрдүүлж байгаа бол Хаан банк болон Голомт банкны хувьд өсөлтийн ихэнх хэсгийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлэв. Хаан банк нь 2021 оны 3 дугаар улиралд хувь нийлүүлсэн хөрөнгөө 3 дахин нэмэгдүүлж, 172 тэрбум төгрөг болгосон юм.

Тайлант хугацаанд банкны салбарын зээлийн багц сэргэсэн дүр зурагтай байна. Хаан банк болон Төрийн банкны зээлийн багц хамгийн ихээр нэмэгдэхэд Засгийн газраас хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зээл ихээр нөлөөлжээ. Учир нь уг хөтөлбөр нь иргэд болон жижиг дунд бизнесүүдийг дэмжих зориулалттай бөгөөд иргэдийн банк суурьтай банкуудаар голчлон олгогдсон болохыг үүнээс харж болно.


Тайлант хугацаанд Төрийн банк зээл олголтоо дэмжиж, харин хөрөнгө оруулалт болон бусад санхүүгийн хөрөнгөө бууруулсан. Харин Голомт банкны хувьд 2020 оны турш тасралтгүй буурсан зээлийн багцаа буцаан нэмэгдүүлж, 3.4 их наяд төгрөгт хүргэсэн нь цар тахлаас хойших хамгийн өндөр өсөлт нь болж байна.

Тайлант хугацаанд Голомт банкны харилцах, хадгаламж үл мэдэг буурав. Үүнд татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4% буурч, 3.6 их наяд төгрөг болсон нь нөлөөлжээ. Харин зээл олголтоор дамжин иргэдийн гар дээрх бэлэн мөнгө нэмэгдсэнээр бусад банкуудын татан төвлөрүүлсэн эх үүсвэр нэмэгдсэн байна.


Зураг 1: Банкуудын актив (их наяд төгрөг)




Зураг 2: Банкуудын өөрийн хөрөнгө (их наяд төгрөг)



Зураг 3: Банкуудын цэвэр зээл (их наяд төгрөг)




Зураг 4: Банкуудын харилцах ба хадгаламж (их наяд төгрөг)



Орлогын үзүүлэлтүүд:


Тайлант хугацаанд системийн нөлөө бүхий банкуудын цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс өндөр өсөлттэй гарсан бөгөөд үүнд нь харилцах, хугацаагүй хадгаламжийн хүүг тэглэсэн явдал хамгийн ихээр нөлөөлж, банкуудын ашигт ажиллагааг дэмжлээ.

Зураг 5: Банкуудын 2021Q3: Хүү шимтгэлийн орлого ба цэвэр ашиг (тэрбум төгрөг), ашгийн өсөлт




- Хаан банкны хувьд цэвэр хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 43% өсөж, 441 тэрбум төгрөгт хүрсэн ба хүүгийн орлогын өсөлтөөс илүүтэйгээр харилцах, хадгаламжийн хүүгийн зардал буурсан нь голчлон нөлөөлсөн байна. Мөн иргэдийн зээл олголт, зээлийн нөхцөл өөрчлөлтүүд их хийгдсэнтэй холбоотойгоор банкны бүтээгдэхүүн үйлчилгээнээс олох шимтгэлийн орлого 37 тэрбум төгрөгөөр өсөж, арилжаанаас 16.7 тэрбумын зардал хэмнэсэн зэрэг нь ашигт ажиллагааг дэмжиж өгчээ.
- Худалдаа хөгжлийн банкны хувьд цэвэр хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 4% бага буюу 151.8 тэрбум төгрөг болсон ч эрсдэлийн сангийн зардал болон үндсэн үйл ажиллагааны бус шинжтэй ханшийн тэгшитгэлийн зардал буурсан нь (өмнөх оны мөн үеэс 102 тэрбум төгрөгөөр бага гарсан) цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өсөж, 77.5 тэрбум төгрөг гарахад голчлон нөлөөлсөн байна.
- Голомт банкны хувьд нийт хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 5% өсч, 426 тэрбум төгрөг болоход үнэт цааснаас олсон орлого голлох үүргийг гүйцэтгэсэн байна. Нөгөөтэйгүүр хүүгийн зардал өмнөх оны мөн үеэс 20% буурсан нь ашигт ажиллагааг хамгийн их дэмжив. Тайлант улирлын хүүгийн зардал нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад даруй 40 гаруй тэрбум төгрөгөөр буурсан болох нь харагдаж байгаа юм. Үүний ачаар цэвэр хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 2 дахин өссөн боловч ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого огцом буурсан нь уг өсөлтийг саарууллаа. Голомт банк нь ханшийн тэгшитгэлээс нийт хүүгийн орлогын дунджаар 10%-тай тэнцэхүйц хэмжээний орлогыг олдог бөгөөд хэлбэлзэл өндөртэй байдаг. Тиймээс цэвэр ашиг 11% өсч, 17.7 тэрбум төгрөгийн ашигтай ажиллахад харилцах болон хугацаагүй хадгаламжийн хүүг тэглэсэн нь хамгийн чухал ашгийн дэмжигч болох нь харагдаж байна.
- Төрийн банкны хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 1% буурсан ч нөгөөтэйгүүр хүүгийн зардал 16% буурснаар цэвэр хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 24% өсөж, 131 тэрбум төгрөг болжээ. Үүнээс харахад Төрийн банкны хувьд ч харилцах болон хугацаагүй хадгаламжийн хүүг тэглэсэн нь банкны ашигт ажиллагааг дэмжих гол хөшүүрэг болж байна.
- Бага хүүтэй зээлийн нөлөөгөөр хүүгийн орлого буурсан хэдий ч харилцах, хугацаагүй хадгаламжид тооцох хүү буурснаар цэвэр хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 30% өсөж, 99.6 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнээс гадна, эрсдэлийн сангийн зардал огцом буурсан нь ашигт ажиллагааг ихээр дэмжиж, өмнөх оны мөн үеэс 2 дахин өндөр буюу 41 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Зураг 6: Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь (NPL)



Тайлант улиралд эдгээр 5 банкны зээлийн багцын чанар сайжирсан болох нь дээрх байдлаар харагдаж байна. Банкуудын зээл олголт сэргэхэд хэвийн зээлийн багцууд өсөлттэй байсан хэдий ч чанаргүй зээлийн өсөлт хэвийн зээлийн өсөлтөөс бага байсан нь банкны салбарын үзүүлэлт, цаашлаад эдийн засгийн нөхцөл байдал ковидоос өмнөх байдал руу аажмаар шилжих, дасан зохицох үйл явц явагдаж буйг харуулж байгаа юм. Гэвч хэрэглээний зээлийн чанаргүйдэл өмнөх үетэй адил хэвээр байна. Жишээлбэл, Төрийн банкны зээлийн багц 25% өсөхөд чанаргүй зээл дагаад 23% өссөн байна.

Зураг 7: Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)




Хамгийн өндөр өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажилласан банк нь Хаан банк байсан бөгөөд банкны хувьд цэвэр ашгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 дахин өсөж, 229.5 тэрбум төгрөгийн ашиг тайлагнаснаар ROE буюу өөрийн хөрөнгийн өгөөж 21.8% гарсан. Энэ нь сүүлийн 5 жилийн гүйцэтгэлээс харахад түүхэн дээд хэмжээ юм.

Үүний дараагаар Хас банк, 17.7% өгөөжтэй ажиллаж буй бөгөөд 2019 оноос хойш өсөж байна. Харин бусад гурван банкны өгөөжийн хөдөлгөөнийг зургаас харах боломжтой.


Дээрх зургаас харахад Худалдаа хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн өгөөж 2020 оны жилийн эцэс, 2021 оны эхний улиралд хамгийн бага түвшиндээ буюу 2%-ийн орчимд байжээ. Худалдаа хөгжлийн банк нь 2020 оны сүүлээр Улаанбаатар хотын банкыг өөртөө нэгтгэж, эздийн өмчийн дүн нэмэгдсэн ч цэвэр ашиг буурсан тул ийнхүү өгөөж бууралттай гарсан байж болзошгүй. Харин 2021 оны хагас жилээс эхлэн эргэн сэргэж байна.

Зураг 8: Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



Монгол банкнаас баталсан төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа нь 25% байдаг. Системийн нөлөө бүхий банкууд нь уг харьцаан үзүүлэлтийг хангасаар ирсэн бөгөөд өнгөрсөн жилүүдийн хувьд хамгийн өндөр үзүүлэлттэй нь Хаан банк байсан бол тайлант хугацаанд Хас банкны үзүүлэлт өсөж 49.7% болсон байна. Мөн Худалдаа хөгжлийн банкнаас бусад банкны үзүүлэлт 2020 оны жилийн эцэстэй харьцуулахад буурсан байна.

Зураг 9: 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа



Монгол банкнаас баталсан 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа 9% байдаг. Дээрх зургаас Хас банкны харьцаан үзүүлэлт жил ирэх тусам сайжирч байгааг харж болно. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс гадна нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээг ашиглан банкны одоо байгаа өөрийн хөрөнгөдөө үндэслэн эрсдэлтэй активаа нэмэгдүүлэх боломжийг тооцоолж болно. Нийт өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 12% байдаг ба Голомт банкны уг үзүүлэлт тайлант хугацаанд 12.5% байсан байна. Үүнээс харахад Голомт банк нь өөрийн хөрөнгийн зохистой хэмжээнд тултал активаа нэмэгдүүлсэн байгаа бол бусад банкууд нь активаа тодорхой хэмжээнд өсгөх боломжтой юм.

Мөн эдгээр таван банкны хувьд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон нийт өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн активт харьцуулсан харьцаанууд нь ижил байдаг. Энэ нь банкуудын өөрийн хөрөнгө дан нэгдүгээр зэрэглэлийн хөрөнгөөс бүрдэж буйг илэрхийлж байгаа юм.

Эх сурвалж: Банкуудын 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, Монгол банкны банкуудын нэгдсэн тайлан



ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОАНТ БОЛГО

BANKREFORMER

АНДЕРРАЙТЕРИЙН ХЭЛТЭС БЭЛТГЭВ.

